



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 1107

Улаанбаатар хот

Ахмадын сан байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.2, 1.3, 1.5, 3.12 дахь хэсэг, 2.1.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 5 дугаар зүйлийн 5.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын ахмад настнуудад тусламж, дэмжлэг үзүүлэх зорилгоор “Ахмадын сан” байгуулсугай.

2. “Ахмадын сан”-гийн дансыг нийслэлийн төрийн санд нээлгэн, жил бүрийн цалингийн сангийн 0.1 хувиар тооцон санг бүрдүүлэхийг Ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д зөвшөөрсүгэй.

3. “Ахмадын сан”-гийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, хууль журамд заасан хугацаанд тайлагнаж ажиллахыг Ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Д.Ганболд)-т тус тус даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

